



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/21

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2026 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн 04 дүгээр зөвлөмжийн дагуу ӨВАБОЭТ/20260102010/01/01 урилгын дугаартай эм эмнэлгийн хэрэгсэл урвалжийн тендерийн дахин үнэлгээ хийсэн 3 багцыг нийлүүлэхээр 25 дугаар багц мэс заслын хэрэгсэл-2-ийг 22,300,000 (хорин хоёр сая гурван зуун мянга) төгрөгөөр Монос трейд ХХК-иар, 40 дүгээр багц нян судлалын урвалжийг 97,368,200 (ерэн долоон сая гурван зуун жаран найман мянга хоёр зуун) төгрөгөөр Монс трейд ХХК-иар, 46 дугаар багц сериологийн лабораторийн урвалжийг 89,950,000 (наян есөн сая есөн зуун тавин мянган) төгрөгөөр Монбиофарм ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сургалт хөгжил, бодлого төлөвлөлт, гүйцэтгэлийн албаны дарга (Д.Аззаяа) даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр)-т зөвшөөрсүгэй.

4. 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/18 дугаартай тушаалаар эрх олгосон 25 дугаар багц мэс заслын хэрэгсэл-2-ийг нийлүүлэхээр шалгарсан Медиконт ХХКомпани, 40 дүгээр багц нян судлалын урвалж хүчингүй болгож дахин зарлах, 46 дугаар багц сериологийн лабораторийн урвалжийг нийлүүлэхээр шалгарсан И Эл Ди Эй ХХКомпаниудад олгосон гэрээ байгуулах эрх болон дахин зарлах шийдвэрийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАХИРАЛ



Г.ДАШЖАНЦАН